

Орчин үеийн Орос-Хятад-Монгол гурван улсын хамтын ажиллагааны хүрээн дэх шинжлэх ухааны салбарын дипломат харилцаа

Бойкова Елена Владимировна

ОХУ-ын ШУА-ын Дорно дахины хүрээлэн, Москва

Цахим хаяг: e.boykova@hotmail.com

Орчуулсан

ОУХХ-ийн Орос судлалын салбарын ЭША. Д.Туул

Хураангуй: Шинжлэх ухааны салбарын дипломат харилцаа нь орчин үеийн Хятад, Монгол, Орос гурван талын түншлэлийн нэг цогц чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Гурван улсын эрдэмтдийн дипломат харилцаа нь улсуудын хоорондоо холбоо тогтоох ирээдүйтэй хэлбэр бөгөөд олон улсын харилцаанд, түүнчлэн, Зүүн хойд Азид эрдэмтдийн хамтын ажиллагааны үзүүлэх үйлчлэл, нөлөө багагүй нөөц бололцоотой билээ. Шинжлэх ухааны салбарын дипломат харилцаа нь Орос, Хятад, Монгол гурван улсын төлөөлөгч - төрийн бус оролцогчдын хүрээг тэлж өгч, улмаар олон улсын харилцаанд оролцогчдын тоог нэмэгдүүлдэг. Гурван улсын эрдэмтэд төрөл бүрийн салбарт хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлж, ихээхэн туршилага хуримтлуулсан нь цаашид өөр хоорондоо гурван талын холбоо харилцааг өргөтгөхөд таатай нөхцөл бүрдэх тухай яриа өрнүүлэх боломжийг бүрдүүлж байна. Гурван улсын эрдэмтдийн хамтын ажиллагаа нь олон нийтийн дипломат харилцааны нэг хэлбэр бөгөөд энэ харилцааны хүрээнд явагддаг үйл ажиллагаанд оролцогчид шинжлэх ухааны болон олон нийтийн салбарт хийгдэх ажлуудыг өөрсдийн хүрээнд хамруулаад явдаг.

Түлхүүр үгс: шинжлэх ухааны салбарын дипломат харилцаа, Хятад-Монгол-Орос гурван улсын эдийн засгийн коридор, гурван талын харилцан хамтын ажиллагаа, олон нийтийн дипломат харилцаа, Зүүн Хойд Азийн олон улсын харилцаа.

Орчин үеийн олон улсын харилцаан дахь шинжлэх ухааны салбарын дипломат ажиллагааны үүрэг

Сүүлийн жилүүдэд улс хоорондын харилцаанд олон нийтийн дипломат харилцааны үүрэг мэдэгдэхүйц өсөн нэмэгдээд байна. Олон нийтийн дипломат харилцаа (public diplomacy) гэдэгт улс төрийн зорилгоор гадаадын олон нийтийн байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагааны тогтолцоог ойлгоно¹.

Шинжлэх ухааны дипломат харилцаа нь олон нийтийн дипломат ажиллагааны нэг хэсэг болохын хувьд олон улсын шинж чанартай гэдгийг харгалзан улс орнуудын олон талын болон хоёр талын харилцааны чухал хэрэгсэл болж байна. ЮНЕСКО-гоос хэрэгжүүлдэг хөтөлбөрийн нэг болох Дэлхийн шинжлэх ухааны академийн (TWAS) вэбсайтад тэмдэглэснээр, өнөөдөр шинжлэх ухааны дипломат харилцааны хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдэж байна. Хоорондын яриа хэлэлцээр нь улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулаад зогсохгүй улс хоорондын улс төрийн харилцаа хүндэрсэн тохиолдолд харилцан итгэлцлийг бэхжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой юм². Сүүлийн жилүүдэд шинжлэх ухаан нь аливаа улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэсэн ойлголт гүнзгийрч байна. Дэлхий нийтийн болон хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй асуудлыг

шийдвэрлэхэд, гадаад харилцааны байгууллагын ажилтнуудын хамт эрдэмтэд ч мөн адил энэ талаар ажиллах боломжтой болох нь тодорхой болж байна.

Энэ талын хамтын ажиллагааг «хоёрдогч дипломат харилцаа» (Track II Diplomacy) гэх ойлголтод хамааруулдаг. Өөрөөр хэлбэл, энэ хүрээнд мэргэжлийн нийгэмлэг дипломат харилцаа явуулах бөгөөд энэ нь орчин үеийн олон улсын харилцааны тогтолцоонд шинжлэх ухааны салбарын дипломат харилцааны гүйцэтгэх үүрэг, нөөц бололцоог нэмэгдүүлээд байна. Шинжлэх ухааны дипломат харилцаа гэдэг нь ихэнх улс орнуудын хувьд асуудлыг шийдвэрлэхийн тулд шинжлэх ухааны салбар дахь хамтын ажиллагааг ашиглах явдал юм.

Судлаач М.Д.Романовагийн хэлснээр “шинжлэх ухааны үнэт зүйлс болох оновчтой, объектив, олон талт байдал нь дэлхий даяар ижил байдаг. Улс төрчид, эрдэмтэн судлаачид энэ үнэт зүйлс, түүнийг дагаж мөрдөх нь улс хоорондын харилцааг сайжруулж, итгэлцлийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг гэдэгтэй улам бүр санал нэгдэж байна. Шинжлэх ухаан бол улс төрийн үзэл суртлын нөлөөнөөс ангид, соёл, үндэсний болон шашин шүтлэгийн ялгаанаас үл хамааран

1 См.: Долгинский А. Что такое общественная дипломатия и зачем она нужна России? // <https://russiancouncil.ru/analytics-and-comments/analytics/chto-takoe-obshchestvennaya-diplomatiya-i-zachem-ona-nuzhna/> (дата обращения: 12.06.2019).

2 The World Academy of Sciences (TWAS). URL: <https://twas.org/science-diplomacy> (дата обращения 17.03.2020).

чөлөөтэй үзэл бодлоо солилцох талбар юм³.

Шинжлэх ухааны дипломат харилцаа нь нийтлэг асуудлыг шийдвэрлэх, олон улсын бат бөх түншлэлийг бий болгохын тулд улс орон, бүс нутаг, нийгэмлэг хоорондын шинжлэх ухаан, технологийн болон эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг янз бүрийн хэлбэрээр явуулж байдаг. Үүнд үндэстэн, нийгэмлэг хоорондын эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан, техникийн салбарын солилцооны хэд хэдэн төрлийг багтаадаг⁴.

«Шинжлэх ухааны дипломат харилцаа» гэсэн ойлголт нь гурван чиглэлтэй байдаг: science in diplomacy буюу дипломат харилцааны шинжлэх ухаан - (төрийн гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулахад эрдэмтэн, судлаачдыг татан оролцуулах), diplomacy for science буюу шинжлэх ухааны дипломат харилцаа - (шинжлэх ухааны дипломат ажил) - олон улсын эрдэм шинжилгээний хамтын ажиллагааны үйл явцын дипломат ажиллагаа), science for diplomacy буюу дипломат харилцааны шинжлэх ухаан - (олон улсын харилцааг бэхжүүлэхийн тулд эрдэм шинжилгээний хамтын ажиллагааны боломжийг ашиглах, тэр дундаа улс орнууд хоорондын хамтын ажиллагаа).

Хүмүүнлэгийн хамтын

ажиллагааны хүрээн дэх эрдэм шинжилгээний дипломат ажиллагааны чиглэл улс орон, ард түмэн хоорондын харилцаанд улам бүр мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэж байна. ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин Азербайджан улсын парламент Милли меджлист 2001 оны нэгдүгээр сарын 10-нд үг хэлэхдээ «Бид соёл урлаг, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа, боловсролын чиглэлийн холбоо харилцааг өргөжүүлэх шаардлагатай. Хүмүүнлэгийн холбоо харилцаа л хүмүүсийг илүүтэй ойртуулж, харилцан нэгэндээ итгэх итгэлийг бэхжүүлдэг ... »⁵ хэмээн цохон тэмдэглэж байсан. «Дипломат харилцааны уламжлалт хэлбэрүүд асуудлыг шийдвэрлэж дөнгөөгүй үед төрийн байгууллагуудтай үр өгөөжтэй хамтран ажиллахад»⁶ шинжлэх ухааны салбарын дипломат харилцааг цөөнгүй тохиолдолд ашигласан тухай Оросын эрдэмтэд тэмдэглэдэг. Харилцаа нэгэнт хүндэрсэн, эсвэл хүндрэл гарч болзошгүй байдлыг намжаах, мөн улс хоорондын хамтын ажиллагааны хөгжлийн явцыг нааштайгаар зохицуулах боломжийг эрдэмтдийн харилцан хамтын ажиллагаа бий болгодгийг туршлага харуулж байна.

Олон нийтийн үйл ажиллагаанд шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны гүйцэтгэх үүргийг дараах үндсэн хэлбэрээр харж болно. Үүнд: улсын гадаад бодлогын үйл

3 Романова М. Д. Научная дипломатия: измерения и практики // Наука. Инновации. Образование. 2017. № 1 (23). С. 40.

4 См. сайт независимой общественной инициативы SciTechDiploHub (the Barcelona Science and Technology Diplomacy Hub): URL: <http://www.scitechdiplohub.org/> (дата обращения: 11.04.2020).

5 <http://kremlin.ru/events/president/transcripts/21160> (дата обращения: 12.06.2019).

6 Ибрагимова К. А., Барабанов О. Н. О перспективах российской научной дипломатии // Вестник РФФИ. № 1 (97). Январь–март 2018 г. С. 54.

ажиллагааны тодорхой чиглэл ба ерөнхий байдлыг тодорхойлоход нарийн мэргэшсэн мэргэжилтнүүд оролцох, олон нийтийн хамтын ажиллагааны нэг хэлбэр гэдэг утгаар шинжлэх ухааны хамтын ажиллагааг хөгжүүлэх ба төгөлдөржүүлэх, улс хоорондын харилцааг сайжруулах ба тогтворжуулахад хувь нэмэр оруулах, өөрийн орны талаар нааштай дүр төрхийг бий болгох зэрэг болно. Эдгээр хэлбэрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжлийн болон дүн шинжилгээний төвүүд (Thinktanks) гол үүрэг гүйцэтгэх ба мэргэжилтнүүдэд хүртээмжтэй дараах арга ажиллагааг

ашиглана. Үүнд: төрөл бүрийн шинжлэх ухааны болон онол-практикийн үйл ажиллагааг зохион байгуулах, харилцаа холбооны нэмэлт сувгуудийг бий болгох, мэдээлэл авах, судалгаа хийх ба зөвлөмж боловсруулах, судлагдсан үйл ажиллагаа ба үйл явдлуудыг мэдээлэл-дүн шинжилгээтэй дүйцүүлэх⁷ зэрэг юм.

Шинжлэх ухааны дипломат ажиллагааны онцлог нь улс орнууд болон төрийн бус байгууллагуудын хооронд уламжлалт бус холбоо байгуулахад туслалцаа үзүүлэх боломж юм⁸.

Орос, Хятад, Монголын түншлэлийн хүрээн дэх шинжлэх ухааны дипломат харилцаа

Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа нь хилийн чанад дахь олон нийттэй харилцах нэг хэлбэр болохын хувьд Хятад, Монгол, Орос гурван талын түншлэлийн цогц үйл ажиллагааны чухал хүчин зүйлүүдийн нэг болоод байна. Түүнчлэн, энэ нь олон нийтийн хамтын ажиллагааны нэг хэлбэр гэдэг утгаар «Хятад-Монгол-Орос гурван улсын эдийн засгийн коридор» байгуулах төслийн гишүүн-орнууд үндэсний ашиг сонирхлоо дэвшүүлэх, хамгаалах арга хэрэгсэл болох юм. Учир нь улс бүрийн шинжлэх ухааны байгууллагууд, судлаачид судалгааны төслүүдэд оролцон, нөгөө орнуудын судлаачидтай харилцан хамтарч ажиллахдаа үндэсний ашиг сонирхлоо

хамгаалж байдаг. Энэ үүднээс авч үзвэл эрдэмтэд бол өөрийн орны үндэсний ашиг сонирхлыг тээж яваа хүмүүс юм. Нөгөө талаас, олон улсын төслүүдэд гурван улсын эрдэмтэд олноороо хамтран ажиллах нь нийтлэг ашиг сонирхлоо хамгаалан нэгэн нэгдмэл хүч болох боломжтой.

Шинжлэх ухааны салбарын дипломат харилцаа нь Орос, Хятад, Монгол гурван улсын төлөөлөгч - төрийн бус оролцогчдын хүрээг тэлж өгч, улмаар олон улсын хүмүүнлэгийн харилцааны цогц үйл ажиллагаанд шинэ оролцогчдыг татан оруулах явдал юм. Гурван улсын эрдэмтдийн хамтын ажиллагаа нь олон нийтийн дипломат харилцааны нэг хэлбэр бөгөөд энэ харилцааны хүрээнд

7 Букалова С. В. Научная дипломатия: сущность и роль в системе международных отношений // Мировая политика. 2018. № 2. С. 96.

8 Романова М. Д. Указ. соч. С. 40–41.

явагддаг үйл ажиллагаанд оролцогчид шинжлэх ухааны болон олон нийтийн салбарт хийгдэх ажлуудыг өөрсдийн хүрээнд хамруулаад явдаг. Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа нь өөрийн өвөрмөц шинж чанараас үүдэн цэвэр мэргэжлийн ашиг сонирхолд хөтлөгдөн үйл ажиллагааны хүрээнээс халих нь цөөнгүй бөгөөд «зөөлөн хүчний» бодлогын хэсэг болж, улмаар аль нэг улсын бодлогын үндсэн үүрэг даалгавартай холбоотой улс төрийн чиг баримжаатай болдог. Шинжлэх ухааны дипломат харилцаа нь олон улсын тавцанд ихэнх улсын “зөөлөн хүч”-ний бодлогын гол түлхүүр нь болдог гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ байр сууринаас авч үзвэл, эрдэмтдийн хамтын ажиллагаа нь аль нэг улсын гадаад бодлогын үйл ажиллагааг «зөөлөн хүчний» аргаар хэрэгжүүлэхэд түлхэц болдог. «Хятад-Монгол-Орос гурван улсын эдийн засгийн коридор» байгуулах төслийн тухайд бол эрдэмтэд төслийн агуулга ба ач холбогдлыг Хятад, Монгол, Орос гурван улсын цаашдын эдийн засгийн хөгжлийн хувьд ч, Их Евразийн хэтийн төлвийн хувьд ч хамтран судалж, тодруулах ба үүнтэй зэрэгцээд энэхүү төслийг шинжлэх ухааны талаас харах ч боломжтой, судлах ч ёстой юм.

Шинжилгээ судалгааны салбар дахь гурван улсын эрдэмтдийн хамтын ажиллагаа нь улс тус бүрийн удирдлагаас эхлээд жирийн иргэн хүртэлх гурван улсын хамтын ажиллагааны цогц харилцааны нэгээхэн хэсэг юм. Хятад, Монгол, Оросын эрдэмтэд хамтран ажилласнаар “Эдийн засгийн коридор”-ын төслийн

хүрээн дэх төрөл бүрийн чиглэлд зөвхөн мэргэжлийн зөвлөмж гаргах төдийгүй, эцсийн дүндээ, улс бүрийн хөгжилд дөхөм болох юм.

Орос, Монгол, Хятад улсууд шинжлэх ухааны болон хүмүүнлэгийн ухааны салбарт хоёр талын харилцан хамтын ажиллагааны багагүй туршлага хуримтлуулсан. Орос, Монголын болон, Орос, Хятадын хоорондын эрдэм шинжилгээний салбарын хамтын ажиллагаа 100 орчим жилийн түүхтэй. Орчин үед Суурь Судалгааны Оросын Сан (РФФИ) ба БНХАУ-ын Нийгмийн Шинжлэх Ухааны Академи хамтран, мөн Суурь Судалгааны Оросын Сан (РФФИ) ба Монголын БСШУЯ хамтран явуулдаг уралдаануудын хүрээнд шинжлэх ухааны төслүүд хэрэгжүүлж ирсэн хоёр талын хамтын ажиллагааны арвин туршлага бий. Энэ салбар дахь ололт амжилтуудаас улбаалан Хятад, Монгол, Орос улсуудын хооронд гурван талын харилцаа холбоог өргөжүүлэх цаашдын таатай нөхцлийн талаар яриа өрнүүлэх бүрэн боломжтой. Түүнчлэн гурван талын шинжлэх ухааны хамтын ажиллагаа эхний шатандаа байгаа, мөн Орос-Хятад-Монголын харилцаан дахь шинжлэх ухааны дипломат харилцааны боломж бололцоо одоохондоо бүрэн дүүрэн ашиглагдахгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Бидний бодлоор гурван талын хамтын ажиллагаа зөвхөн «Хятад-Монгол-Орос гурван улсын эдийн засгийн коридор» байгуулах төслийн хүрээгээр хязгаарлагдах ёсгүй. Учир нь нарийн шинжлэх ухааны салбарт ч, мөн хүмүүнлэгийн шинжлэх

ухааны хүрээнд ч хуримтлагдсан хамтын ажиллагааны туршлага нь төрөл бүрийн чиглэлийн судалгаанд хамтран ажиллах өргөн боломж, ирээдүй байгааг илтгэж байна. Шинжлэх ухааны дипломат харилцаа нь хүмүүнлэгийн хамтын ажиллагааны нэг хэсэг бөгөөд хүмүүнлэгийн хамтын ажиллагаа нь албан ёсны төрийн бодлого бүрэлдэхэд онцгой нөлөө үзүүлдэг. Энэ үүднээс үзвэл, Зүүн Хойд Азийн геополитикийн асуудлуудын талаарх эрдэмтдийн судалгааг анхаарах нь зүйтэй.

Гурван улсын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны тулгамдаад буй чиглэл бол: «Хятад-Монгол-Орос гурван улсын эдийн засгийн коридор» байгуулах төслийг шинжлэх ухааны мэдээллээр хангах; төрөл бүрийн салбарууд дахь гурван талын шинжлэх ухааны болон бусад хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; гурван улсын хоорондын харилцааг цаашид төгөлдөржүүлэхэд шинжлэх ухааны хамтын ажиллагааг ашиглах, «Эдийн засгийн коридор» ба «Нэг бүс, нэг зам» төслүүдийг хэрэгжүүлэхэд таатай нөхцлийг бүрдүүлэх үүднээс Зүүн Хойд Азийн бүс нутагт энх тайван, тогтвортой байдлыг хангах зэрэг юм. Гурван улсын эрдэмтэд геополитик, иргэншил хоорондын харилцаа, экологи, хүн ам, нийгмийн хүрээ, залуучуудын нийгэмд эзлэх байр суурь ба үүрэг гэх мэт бүс нутгийн болон дэлхий нийтэд тулгамдаад байгаа асуудлуудаар дүн шинжилгээ хийж, мэргэжлийн үнэлгээ гаргаж болох ба эдгээр асуудлаар мэргэжлийн зөвлөмж өгнө.

Хүмүүнлэгийн салбар дахь гурван талын харилцан хамтын ажиллагааны үүрэг байнга өсөн нэмэгдсээр байна. Орос, Хятад, Монгол улсуудын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны хүрээнд бүс нутгийн болон олон улсын асуудлуудаар хийх судалгааг нэмэгдүүлэх шаардалагатай. Энэ нь эцсийн дүндээ Зүүн Хойд Азид ч, дэлхийн тавцанд ч эдгээр улсуудын стратегийн хамтын ажиллагааг бэхжүүлэх юм.

Олон нийтийн хамтын ажиллагааны хэлбэрүүдийн нэг бол гурван улс тус бүрт явагддаг сэдэвчилсэн онууд бөгөөд энэ нь хүмүүнлэгийн салбар дахь хамтын ажиллагаанд зориулж төрөл бүрийн чиглэлээр хийдэг үйл ажиллагаа юм. Өргөн хүрээнд хийгдэх харилцан хамтын ажиллагааны үр өгөөжтэй талбар бол дараалуулж, эсвэл нэгэн зэрэг улс тус бүрт зохион байгуулж болохуйц шинжлэх ухааны (мөн боловсролын) Жил юм.

Анх 2015 онд Хятадын талын санаачлагаар зохион байгуулагдсан Орос, Хятад, Монголын мэргэжлийн төвүүдийн (Thinktank) олон улсын форум бол «Хятад-Монгол-Орос гурван улсын эдийн засгийн коридор» байгуулах төслийн онолын салбар дахь гурван улсын эрдэмтдийн хамтын ажиллагааны нэг жишээ юм. Өнгөрсөн жилүүдэд энэ форум гурван талын шинжлэх ухааны салбарт явагдах солилцооны байнгын төв, гурван улсын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны хүрээн дэх нэр хүнд бүхий мэргэжлийн бүтэц болсон. Өнгөрсөн жилүүдэд гурван улсын мэргэжлийн төв (Thinktank)

шинжлэх ухааны баттай үр өгөөжийг гэрчиллээ. Энэ төвийн үйл ажиллагааг цаашид төгөлдөржүүлэх зорилгоор гурван улсын эрдэмтэд Хятад, Орос, Монгол улсуудын хоёр ба гурван талт хамтын ажиллагааны төрөл бүрийн хүчин зүйлстэй холбоотой асуудлууд, эдийн засгийн коридорыг байгуулах, хэтдээ үүнийг дэлхийн бүсийн төсөл болгох тухай, улс тус бүрийн дотоодын хөгжлийн асуудал, тэдгээрийн соёл иргэншлийн хөгжил гэх мэт судалгааны үр дүнгүүдийг нийтлэх боломжтой олон улсын шинжлэх ухааны сэтгүүл эрхлэн гаргах нь зүйтэй. Орчин үеийн нийгэм дэх залуучуудын үүрэг, төрд оролцох тэдний оролцоо гэсэн гурван улсын залуучуудын талаарх бодлоготой холбоотой асуудлуудад онцгой анхаарал хандуулах шаардлагатай болов уу. Эдийн засгийн коридор байгуулах, мөн гурван талын эдийн засгийн ба улс төрийн хамтын ажиллагааг бий болгох асуудлаар залуу эрдэмтдийн байнгын семинар зохион байгуулах нь шинжлэх ухааны хамтын ажиллагааны чухал хэлбэр байж болох юм. Энэ зорилгоор Орос, Монгол, Хятадын шинжлэх ухааны төвүүдийн хооронд ийм төслийн санхүүжилттэй хамааралтай асуудлуудыг багтаасан хамтын

ажиллагааны гэрээ байгуулах нь зүйтэй.

Гурван талын шинжлэх ухааны салбарын харилцан хамтын ажиллагааны механизмыг төгөлдөржүүлэх нь Хятад, Орос, Монгол улсуудын шинжлэх ухааны нийгэмлэгийн төдийгүй эдгээр улсуудын төрийн байгууллагуудын чухал үүрэг даалгавар юм. Үүнтэй холбоотойгоор төрийн байгууллагууд ч академийн бүтэц ч гурван талын шинжлэх ухааны гэрээ хэлэлцээрийг боловсруулах, байгуулах тухай бодох хэрэгтэй нь харагдаж байна.

Гурван улсын эрдэмтэд харилцан хамтран ажиллах нь тэдний мэргэжлийн үйл ажиллагаанаас гадна Зүүн Хойд Азийн бүс нутагт стратегийн тогтвортой байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх, олон улсын тавцанд Орос, Монгол, Хятадын үйл ажиллагааг нөхцөлдүүлэх боломжийг бүрдүүлэх юм. Энэ нь дэлхийн улс төр тогтворгүй байгаа өнөө үед онцгой ач холбогдолтой юм. Байнгын яриа хэлэлцээр явагдаж, шинжлэх ухааны хамтын ажиллагааны боломжууд бүрдэх нь гурван улсын хоорондын харилцан ойлголцлыг бэхжүүлэх төдийгүй, илүү өргөн, евразийн том орон зайг бий болгоно.

Дүгнэлт

Олон нийтийн хамтын ажиллагаа нь гадаад бодлогын таатай уур амьсгалыг бүрдүүлэх удаан хугацааны үйл ажиллагааны хэрэгсэл юм⁹. Энэ үүднээс авч үзвэл, Орос, Хятад, Монгол улсуудын шинжлэх ухааны нийгэмлэгийн харилцан хамтын

ажиллагааг цаашид бэхжүүлэх, төгөлдөржүүлэх нь чухал даалгавар юм. Оросын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар, «шинжлэх ухаан бол бүхий л гадаад бодлогын стратеги, тодорхой төлөвлөгөөнүүдийн бүрэлдэхүүн хэсэг байх ёстой»¹⁰ бөгөөд үүнтэй санал

9 Долинский А.Указ. соч.

нийлэхгүй байх аргагүй.

Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны өсөн нэмэгдэж буй бүхий л үүрэг оролцоог харгалзан, Орос, Хятад, Монголын төрийн ба олон нийтийн бүтцүүд олон нийтийн хамтын ажиллагааны энэ чиглэлийн цогц бодлогыг боловсруулж, энэ салбар дахь хамтын ажиллагааны шинэ хэлбэр, чиглэлийг хайж, бий болгох шаардлагатай.

Гурван улсын эрдэмтдийн хамтын ажиллагаа бол олон улсын харилцаанд эергээр нөлөөлөх нөөц бололцоог агуулсан олон улсын холбоо харилцааны ирээдүйтэй хэлбэр юм.

Үүнтэй уялдуулан төрийн байгууллагууд, түүнчлэн эрдэм шинжилгээний байгууллагуудын хувьд гурван талт шинжлэх ухааны хамтын ажиллагааны холбогдох гэрээ,

хэлэлцээрийг боловсруулж, гарын үсэг зурах талаар бодох нь зүйтэй болов уу.

Энэ үүднээс авч үзвэл, гурван улсын эрдэмтдийн хамтын ажиллагаа нь мэргэжлийн үйл ажиллагаанаас гадна Зүүн хойд Азийн стратегийн тогтвортой байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх, орчин үеийн дэлхийн улс төрийн тогтворгүй нөхцөлд онцгой ач холбогдол бүхий Орос, Хятад, Монголын хамтын ажиллагааг олон улсын тавцанд зохицуулах боломжийг олгодог. Байнгын яриа хэлэлцээг тогтмол явуулах замаар шинжлэх ухааны дипломат ажиллагааны боломжууд нь гурван улсын хоорондын харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд төдийгүй өргөн хүрээнд - Евразийн том орон зайг бий болгоход хувь нэмэр оруулдаг.

Ашигласан материал

Долинский А. Что такое общественная дипломатия и зачем она нужна России? // <https://russiancouncil.ru/analytics-and-comments/analytics/chto-takoe-obshchestvennaya-diplomatiya-i-zachem-ona-nuzhna/> (дата обращения: 12.06.2019).¹⁰

The World Academy of Sciences (TWAS). URL: <https://twas.org/science-diplomacy> (дата обращения 17.03.2020).

Романова М. Д. Научная дипломатия: измерения и практики // Наука. Инновации. Образование. 2017. № 1 (23).

The Barcelona Science and Technology Diplomacy Hub): URL: <http://www.scitechdiphohub.org/> (дата обращения: 11.04.2020).

<http://kremlin.ru/events/president/transcripts/21160> (дата обращения: 12.06.2019).

Ибрагимова К. А., Барабанов О. Н. О перспективах российской научной дипломатии // Вестник РФФИ. № 1 (97). Январь–март 2018 г.

Букалова С. В. Научная дипломатия: сущность и роль в системе международных отношений // Мировая политика. 2018. № 2.

¹⁰ Ибрагимова К. А., Барабанов О. Н. Указ. соч.

Science diplomacy within the Russian-Chinese-Mongolian cooperation at the present time

Boykova Elena Vladimirovna

Institute for Oriental Studies Russian Academy of Sciences

Moscow, Russian Federation

E-mail: e.boykova@hotmail.com

Abstract: *Science diplomacy is an increasingly important component of the trilateral partnership complex among China, Mongolia and Russia at the present time. Being a form of public diplomacy, it serves as a means of promoting and protecting national interests of the states that are the parties of the “China-Mongolia-Russia Economic Corridor” project. Diplomacy of scholars of the three countries is a promising format for international contacts with potential impact on international relations, particularly in Northeast Asia. Science diplomacy allows to expand the circle of non-state actors that are representatives of Russia, China and Mongolia, thereby increasing the number of participants of international relations. Scholars of the three countries have accumulated considerable experience of bilateral cooperation in various fields, which suggests that there are favorable prospects for expansion of tripartite contacts among them. Interaction of scholars of the three countries is a form of public diplomacy, in the frames of which the participants of the process combine functions of academic and public figures*

Keywords: *science diplomacy, China-Mongolia-Russia Economic Corridor, tripartite cooperation, public diplomacy, international relations in Northeast Asia.*

<i>The day of submission:</i>	<i>2020.4.29</i>
<i>Completion of review:</i>	<i>2020.5.18</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2020.6.07</i>